

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ
ГАЛ УНТРААХ ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН МАШИН НИЙЛҮҮЛЭХ ТӨСЛИЙН
САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ТУХАЙ

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХООРОНДЫН

САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Сангийн ял,
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА

Гарын үсэг /Signature/

2023 оны 09 сарын 29 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь (цаашид "Талууд" гэх)

Найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжихийг эрмэлздэгээ илэрхийлж

Олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцэх, нийгмийн болон байгаль орчны хариуцлагад тууштай байр суурь сахихын чухлыг тэмдэглэн

Тэгш эрх, харилцан ашигтай байх зарчимд суурилан

Дараах зүйлийг харилцан тохиролцов:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ДҮН, АГУУЛГА

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөлд зориулан Монгол Улсын Засгийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрөв. Энэхүү төсөл нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэлд багтаж буй.

Францын Төрийн сангийн нэн хөнгөлөлттэй зээл хэлбэрээр 13 335 000 € /арван гурван сая гурван зуун гучин таван мянган евро/-ны нийт үнийн дүнтэй энэхүү санхүүгийн дэмжлэг нь дээр дурдсан төслийн гүйцэтгэлийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Франц Улсаас францын бараа, үйлчилгээ худалдан авах;
- Олгосон санхүүгийн дэмжлэгийн 30-аас хэтрэхгүй хувийг монголын болон гуравдагч орны бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулах, холбогдох гэрээг францын гүйцэтгэгчийн хариуцлагын дор хэрэгжүүлнэ.

Энэхүү зээлтэй холбогдох гэрээ эсхүл гэрээнүүдийн гүйцэтгэлийг францын ханган нийлүүлэгч тал хариуцна.

2 ДУГААР ЗҮЙЛ – ТӨСӨЛ САНХҮҮЖҮҮЛЭХ ХЭЛБЭР

Гэрээ тус бүрийн төслийг эхлүүлэх урьдчилгаа төлбөрийг 1 дүгээр зүйлд дурдсан Төслийн хүрээнд Францын Төрийн сангийн зээлээр санхүүжүүлнэ.

Төсөл эхлүүлэх урьдчилгааны дүн нь тээвэр болон даатгалын зардлыг оролцуулалгүйгээр зээлийн нийт дүнгийн арван таван хувь (15%) байна.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлж буй гэрээнүүдийн францын талын ханган нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлнэ.

3 ДУГААР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН НӨХЦӨЛ, ХЭЛБЭР

Францын Төрийн сангийн зээлийн хугацаа 20 жил бөгөөд үндсэн зээлийн төлбөрөөс эхний 5 жил чөлөөлөгдөнө. Зээлийн хүү жилийн 0,282 хувь байна. Үндсэн зээлийг хагас жил тутам ижил хэмжээтэй, дараалсан 40 удаагийн



төлбөрөөр эргүүлэн төлөх ба эхний төлбөрийг тухайн зээл олгогдсон улирал дууссанаас хойш 66 сарын дараа хийнэ. Хүүг үндсэн зээлийн үлдэгдэл дүнгээс бодно. Тухайлбал Францын Төрийн сангаас санхүүжилт олгосон огноо тус бүрээс эхлэн тооцож, хагас жил тутам эргүүлэн төлнө.

Үндсэн зээл, эсхүл зээлийн хүү төлөх огноо нь Францад эсхүл Монголд ажлын бус өдөр таарвал, төлбөрийг дараагийн ажлын эхний өдөр хүртэл хойшлуулна. Үндсэн зээл эсхүл хүүгийн эргэн төлөлтийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлөлт хийх ёстой байсан өдрөөс хийгдсэн өдөр хүртэл хугацаа хэтэрсний хүү тооцно. Хугацаа хэтэрсний хүүг Еврогийн богино хугацааны индекс-Euro Short Term Rate /€STR/-н ханшаар жилийн 4 % нэмж тооцох ба энэ нь жилийн 5 % хэтрэхгүй. Хэрэв хугацаа хэтэрсний хүү нь бүтэн жилээр хоцорвол дээр дурдсан ханшаар хүүгийн хүү тооцно.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрыг төлөөлж Францын нийтийн хөрөнгө оруулалтын банк (Bpifrance Assurance Export) /банкйг төлөөлж Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага/, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн яам, Зээлийн гэрээг байгуулна. Тус гэрээнд Францын Төрийн сангийн зээлийн ашиглах болон эргэн төлөх хэлбэрүүдийг тодотгож өгнө.


4 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨЛБӨР, ТООЦООНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Энэхүү Хэлэлцээртэй холбоотой төлбөр, тооцооны мөнгөн тэмдэгт нь евро байна.

5 ДУГААР ЗҮЙЛ – ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ бүрийг байгуулахдаа дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- (i) Урьдчилсан байдлаар төсөлд хийсэн дүгнэлтээс гарсан зааварчилгаатай нийцэж, агуулга, дурдсан үйлчилгээ, холбогдох үнэ өртгийн хувьд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраар баталгаажсан байх
- (ii) Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн талаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын дүрэм, журамтай төсөл нийцэж буй эсэхийг шалгасан байх;
- (iii) Монгол Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Францын хөгжлийн агентлаг, Клуб дэ Парис /Club de Paris/-тай байгуулсан өмнөх зээлүүдийн хувьд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
- (iv) Монгол Улсын Засгийн газарт эсхүл түүний аль нэг төрийн байгууллагад олгосон, эсхүл Монгол Улсын Засгийн газар баталгаа гаргасан этгээдэд Франц Улсаас баталгаа гаргаж олгосон банкны зээлийн хүрээнд хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл байгаа эсэхийг шалгасан байх;
- (v) Энэхүү Хэлэлцээрийн 6 болон 7 дугаар зүйлд заасан үүрэг амлалтын биелэлтийн нөхцөлийг хангах;



Энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан төсөлтэй холбоотой гэрээ тус бүр дээрх нөхцөлүүдийг бүрэн гүйцэд хангаж байна гэж францын эрх бүхий байгууллага үзвэл, түүний зөвшөөрлийг үндэслэн Монгол дахь Францын Элчин сайдын яамны Эдийн засгийн албаны дарга Монгол Улсын Сангийн яамтай захидал солилцсоноор уг гэрээ энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж эхлэх үндэс бүрдэнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ – АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Талууд энэхүү Хэлэлцээрийн оршилд олон улсын худалдааны үйл ажиллагаан дахь авлигын эсрэг тэмцлийг дэмждэгээ илэрхийлсэн.

Уг хэлэлцээрийн хүрээнд гэрээ байгуулах талууд нь өөрсдийн болон өөр нэг талын ашиг сонирхлын тулд гуравдагч этгээдэд шууд болон шууд бус замаар хууль бус үйл ажиллагаа, авлига авах нөхцөлийг бүрдүүлж болохуйц шударга бус, мөнгөтэй холбоотой эсвэл бусад давуу талыг санал болгох, олгох, амлах, мөн түүнтэй адилтгах зүйлийг тэднээс шаардаж болохгүй.

Талууд уг төслийн хүрээнд авлигын аливаа үйлдэл бий болгохгүй байх үүрэгтэй. Талууд нь сэжиг бүхий нөхцөл байдлын талаар мэдмэгцээ харилцан мэдээлэх, нөхцөл байдлыг арилгахын тулд шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын сэтгэл ханамжид нийцүүлэх үүрэг хүлээнэ.

Дээр дурдсан үүргүүдийг биелүүлээгүй тохиолдолд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар нь өөрийн зүгээс хамгийн зохимжтой гэж үзэх гэрээ байгуулахаас татгалзах, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгохоор тохиролцсон санхүүгийн тусламжийн төлбөрийг түдгэлзүүлэх, эсхүл Монгол Улсын Засгийн газарт олгосон санхүүжилтийг нийтэд нь эсхүл хэсгийг нь тохирсон хугацаанаас эрт төлөхийг шаардах эрхтэй.

7 ДУГААР ЗҮЙЛ – НИЙГМИЙН БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАРИУЦЛАГЫН ТАЛААР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ АМЛАЛТ

Тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Талууд нь Олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн байгаль орчны болон нийгмийн хэм хэмжээ, үүний дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйл мөн хүрээлэн буй орчны талаарх олон улсын конвенцуудыг, тухайлбал удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенцыг мөн Олон улсыг санхүүгийн корпорацын гүйцэтгэлийн стандартуудыг дагаж мөрдөхийг хөхиүлэн дэмжих шаардлагатай гэдэгт талууд санал нэгдэв.

8 ДУГААР ЗҮЙЛ – БАЙГАЛИЙН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮЕД ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙГ ЦАРЦААХ БОЛОН ХОЙШЛУУЛАХ БОЛОМЖ

23.09.2019 оны
"Басган хот"

Цаг уурын давагдашгүй онцгой үзэгдлийн үед, зээлдэгч тал зээлийн эргэн төлөлтийг түр зогсоох хүсэлтийг, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрыг төлөөлж Францын нийтийн хөрөнгө оруулалтын банк (Bpifrance Assurance Export) /банкийг төлөөлж Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлага/, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Сангийн Яам хооронд байгуулсан Зээлийн гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын Өрийн албанд гаргаж болно.

Энэхүү төслийн хүрээнд хамаарах өр зээлийн үйлчилгээг түр зогсоох хүсэлтийг Францын Өрийн албанд хамгийн ихдээ гурван удаа гаргана.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ – САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХУГАЦАА

Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд заасан санхүүгийн дэмжлэгийг авахын тулд, францын гүйцэтгэгч болон монголын захиалагчийн хооронд гарын үсэг зурсан гэрээний эрх 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор нээгдсэн байна.

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд олгож буй Францын Төрийн Сангийн зээлийн хөрөнгийг 2028 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор ашиглаж дууссан байна.

Зөвхөн онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд дээрх хугацааг Талууд албан бичиг солилцон харилцан санал нэгдсэний дараа сунгаж болно.

10 ДУГААР ЗҮЙЛ – ТАТВАР, ХУРААМЖ

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан татварын хэлэлцээрт өөрөөр заасан байсан ч, уг Хэлэлцээрийн хүрээнд төлөвлөсөн санхүүжилтийг Монгол Улсын хөгжилд бүрэн ашиглах үүднээс энэхүү Хэлэлцээрийн хүрээн дэх франц компаниудын бараа үйлчилгээ, техникийн туслалцаа, тэдгээр ханган нийлүүлэлтийн үйлдвэрлэлд багтаж буй бараа, үйлчилгээг импортлох, экспортлох, худалдан авах, ашиглах, захиран зарцуулах зэрэг үйл ажиллагаанд аливаа гаалийн болон бусад татвар, нийгмийн даатгал, шимтгэлийн хураамж болон Монгол Улсад шаардагддаг бусад ямар ч албан хураамж ногдуулахгүй байхаар тохиролцов.

Хэрэв Монгол Улсад мөрдөгддөг дүрэм, журмын дагуу агуулга, зориулалтаас үл хамааран зайлшгүй татвар, хураамж төлөхөөр болсон тохиолдолд түүнийг францын тал эсвэл францын компаниуд хариуцахгүй.

Мөн энэхүү санхүүгийн Хэлэлцээрийн гүйцэтгэлтэй холбоотой үндсэн зээлийн болон хүүгийн эргэн төлөлт, шимтгэл, хураамж, дагалдах төлбөр нь Монгол Улсад мөрдөгддөг бүхий л албан татвар, хураамж нэмэгдээгүй цэвэр дүнгээр бодогдоно.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ – ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ



Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар өөрийн зардлаар энэхүү хэлэлцээрт тусгасан төслийн зорилго биелсэн эсэхийг эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдээр дүгнэн гаргаж болно. Хэрэв шаардлагатай бол Монгол Улсын Засгийн газар энэхүү судалгааны үр дүнг шууд хүртэх үүднээс үүнд оролцох боломжтой ба оролцох хэлбэрийг тухайлан тодорхойлно. Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас томилсон дээрх судалгаа, дүгнэлт хийх шинжээчдийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авах, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг хүлээнэ.

12 ДУГААР ЗҮЙЛ –ХЭЛЭЛЦЭЭР ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат замаар, бичгээр харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

13 ДУГААР ЗҮЙЛ – ХЭЛЭЛЦЭЭРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Энэхүү хэлэлцээрт Талууд бичгээр санал нэгтэй тохиролцсоныг үндэслэн нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тэдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь уг хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ – МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой үүдэн гарах аливаа маргааныг Талууд харилцан зөвлөлдөх, хэлэлцэх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

Дээр дурдсаныг хүлээн зөвшөөрч хоёр улсын Засгийн газрын эрх бүхий төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурж, тамгалав.

Улаанбаатар хот. оны ... дугаар сарын
Франц, Монгол хэлээр хоёр эх хувь үйлдэв.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

